



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 13 өдөр

Дугаар А/1349

Улаанбаатар хот

Сайжруулсан шахмал түлш
тээвэрлэх, борлуулах, нөөцлөлтийн
үйл ажиллагаанд хяналт шалгалтын
ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 62 дугаар, 2022 оны 223 дугаар тогтоол, Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны 42 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сайжруулсан шахмал түлшний захиалга, нөөцлөлт, тээвэрлэлт, борлуулалтын талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд даалгасугай.

1.1.Сайжруулсан шахмал түлшний борлуулалтын цэг, агуулахын тээвэрлэлтийг жигд хүртээмжтэй, хуваарилалтыг оновчтой зохион байгуулж, "Таван толгой түлш" ХХК-ийн хяналт, борлуулалт, тээвэрлэлтийн нэгдсэн системд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар (Ц.Ганболд)-т;

1.2.Сайжруулсан шахмал түлшний чанар алдагдахаас сэргийлэх зорилгоор 2022 оны 2 дугаар улиралд агуулахад нөөцөлсөн сайжруулсан шахмал түлшийг борлуулалтын цэг рүү хуваарилах, шинэ түлшээр сэлгэх, тээвэрлэх ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар (Ц.Ганболд), "Таван толгой түлш" ХХК (Ц.Даваацэрэн)-д, холбогдох тээврийн санхүүжилтийн зардлыг шийдвэрлэж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Наранбаатар)-т;

2.Хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд үүрэг болгосугай.

2.1.Агаарын чанарыг сайжруулах бүсэд түүхий нүүрс оруулах, сайжруулсан шахмал түлш гаргахыг хориглосон хууль тогтоомжийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцохыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар (С.Даваасүрэн)-т, хураагдсан түүхий нүүрсийг "Амгалан дулааны станц" ХХК-д, сайжруулсан шахмал түлшийг "Таван толгой түлш" ХХК-д тус тус хүлээлгэн өгөх шатахууны зардлыг шийдвэрлэж, тээвэрлэлтийн ажлыг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар (Ц.Ганболд)-т;

111020006227

2.2. Нийслэлийн нутаг дэвсгэр дэх авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоод болон зөвшөөрөгдөөгүй шороон замаар Улаанбаатар хот руу түүхий нүүрс нэвтрүүлэх, хөдөө орон нутаг руу сайжруулсан шахмал түлш гаргахгүй байх, хяналт шалгалтыг сайжруулж, уг ажилд холбогдох байгууллагуудыг татан оролцуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар (С.Даваасүрэн), Нийслэлийн Цагдаагийн удирдах газар (Р.Отгонжаргал); Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн алба (О.Ганболд) болон дүүргүүдийн Засаг дарга нарт;

2.3. Агаарын чанарыг сайжруулах бүсээс сайжруулсан шахмал түлш тээвэрлэн гаргах, түүхий нүүрс оруулахыг завдсан, зөрчил гаргасан этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар иргэн, хуулийн этгээдэд мэдээлэх, сурталчлан таниулах, урьдчилан анхааруулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн Сургалт, судалгаа, олон нийттэй харилцах газар (Г.Хонгорзул)-т;

2.4. Агаарын чанарыг сайжруулах бүсэд зохих зөвшөөрөлгүй түүхий нүүрс хэрэглэж байгаа болон уг бүсээс сайжруулсан шахмал түлш тээвэрлэн гаргах, түүхий нүүрс оруулахыг завдсан этгээдийн зөрчлийн талаар мэдээлсэн иргэн, хуулийн этгээдийг урамшуулах асуудлаар санал боловсруулж, танилцуулахыг Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Г.Содбаяр); Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Наранбаатар)-т;

2.5. Сайжруулсан шахмал түлшний зохистой, аюулгүй хэрэглээ, иргэдийг угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалахтай холбоотой зөвлөмж, мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх, сурталчлах ажлыг тогтмол зохион байгуулж, 24 цагийн шуурхай штабыг байгуулан хяналт тавьж ажиллахыг дүүргүүдийн Засаг дарга нарт;

3. Налайх дүүргийг агаарын чанарыг сайжруулах бүсэд оруулсантай холбогдуулан тус дүүргийн нутаг дэвсгэрээс сайжруулсан шахмал түлш тээвэрлэн гаргах, түүхий нүүрс оруулах зам, постуудад 24 цагаар байнгын эргүүл, хяналт шалгалтын ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагуудын хамт зохион байгуулж ажиллахыг Налайх дүүргийн Засаг дарга Ч.Раднаабазарт үүрэг болгосугай.

4. Агаарын чанарыг сайжруулах бүсэд айл өрхийн хэрэглэж байгаа сайжруулсан шахмал түлшний Сайн картны "Нэг-өрх нэг-карт" зарчмын хэрэгжилтийг судлан, мэдээллийн зөрчил, давхардлыг арилгах замаар түлшний хэрэглээ, захиалгын бүртгэлийн тогтолцоог боловсронгуй болгох ажлыг үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.


5. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч З.Төмөртөмөөд даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Д.СУМЬЯАБАЗАР



Нийслэлийн Засаг даргын 2022 оны
...*10*... сарын ...*13*...-ны өдрийн
...*А.Н.Б.Б. Дорж*... захирамжийн
хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч:	Нийслэлийн нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлыг асуудал хариуцсан орлогч
Гишүүд:	<ul style="list-style-type: none">-Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газрын дарга;-Нийслэлийн Бизнес инновац хөгжлийн газрын дарга;-Нийслэлийн Статистикийн газрын дарга;-Баянгол дүүргийн Засаг дарга;-Баянзүрх дүүргийн Засаг дарга;-Налайх дүүргийн Засаг дарга;-Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга;-Сүхбаатар дүүргийн Засаг дарга;-Хан-Уул дүүргийн Засаг дарга;-Чингэлтэй дүүргийн Засаг дарга;-“Таван толгой түлш” ХХК-ийн Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн дарга;-“Гэрэгэ системс” ХХК-ийн Бизнес хөгжил хариуцсан захирал /тохиролцсоноор/.
Нарийн бичгийн дарга:	Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дарга